



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/378

Булган сум

Цахим тоглоомын газар эрхлэгчдэд тавих
шаардлага, газрын ажиллах цагийн хуваарь
баталж, мөрдүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн хэмжээнд цахим тоглоомын газрын ажиллах цагийн хуваарийг долоо хоногийн Даваа гарагаас Баасан гарагт өглөө 09:00 цагаас орой 22:00 цаг хүртэл, Бямба, Ням гарагт өглөө 10:00 цагаас 22:00 цаг хүртэл, 9-16 насны хүүхдийг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас орой 16:00 цаг хүртэл тоглуулж байхаар баталж, мөрдүүлсүгэй.

2. Цахим тоглоомын газарт Стандарт, хэмжил зүйн хэлтсээс тохирлын гэрчилгээ авч, уг стандарт шаардлагыг хэрэгжүүлж ажиллах, цахим мөрийтэй тоглоом, бооцоот болон тааварт тоглоом тоглуулахгүй байх, цагийн хуваарийг мөрдөн ажиллахыг цахим тоглоомын газруудад даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг) -т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

